

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 01-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2024 оны 6 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2024 оны 6 дугаар сарын байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 16 зорилтын 75 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтад авсан 75 арга хэмжээний 55 арга хэмжээг тус яам толгойлон, 20 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт 60.4 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 70 арга хэмжээний биелэлт 57.7 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 95.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 75 арга хэмжээний биелэлтийг 60.4 хувьтай дүгнэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний товчоо

Зорилго	Зорилтын тоо	Арга хэмжээн ийн тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо							Хэрэгжилт /хувь/
			100	90	70	50	30	0	х/б	
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	1	-	-	-	-	-	-	100

Хоёр. Эдийн засгийн бодлого	11	70	11	10	11	14	17	6	1	57.7
Дөрөв. Засаглалын бодлого	2	2	2	-	-	-	-	-	-	100
Тав. Ногоон хөгжлийн бодлого	2	2	1	1	-	-	-	-	-	95
Дүн	16	75	15	11	11	14	17	6	1	60.4

Дөрөв. Дүгнэлт.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2024 оны 6 дугаар сарын байдлаар **60.4 хувьтай** дүгнэгдсэн бөгөөд 15 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 11 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 11 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 14 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 23 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 0-30 хувь буюу үр дүнгүй, тогтоол, шийдвэрээр зогсоосон хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээ байна.

Тав. Санал, зөвлөмж.

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосныг хэрэгжүүлж ажиллах;

2. Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн, зарцуулсан хөрөнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах;

3. Тайланг тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх;

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
(2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)**

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Холбогдох газар, хэлтэс
1	2	3	4	5	6	7	8	9	
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
1	1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ, ЭТТ, ГХЯ	1,462,473.9	Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх ажлын хүрээнд "Ногоон гарц" түр журам бүрэн хэрэгжсэн. 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 32,181.1 мян.тн нүүрс, 636.6 мян.тн зэсийн баяжмал, 2,916.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 48.6 мян.тн цайрын баяжмал, 456.9 мян.тн хайлуур жоншны баяжмал экспортолсон. Алт олборлолт 6.19 тонн. Нүүрсний экспортын гүйцэтгэл 54.0%, алт олборлолт 30.9%, зэсийн баяжмал 42.0%, төмрийн хүдэр, баяжмал 35.0%, цайрын баяжмал 49.0%, хайлуур жоншны баяжмал 91.0%-ийн гүйцэтгэлтэй байна.	100	УУБГ
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
2	3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.	1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна.	2021 - 2024	"Оюу Толгой" ХХК, УУХҮЯ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК	31,298.1	Далд уурхайн бүтээн байгуулалт 100 хувь.	2024 оны 6 дугаар сарын байдлаар далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 95.4 хувьд хүрээд байна. Ажлын багцуудаар ангилбал налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 97 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 56.1 хувь, агааржуулалтын 3-р ба	70	УУБГ

							4-р босоо амны малталт нэвтрэлтийн ажил дуусаад байна. 2024 оны 1-5 дугаар сард Далд уурхайн бүтээн байгуулалтад 254 сая ам.доллар, нийт төслийн хугацаанд 6,319 сая ам.доллар зарцуулаад байна.		
3		2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	15,649.0	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100 хувьд хүргэнэ.	2020-2022 онд дэлхий нийтийг хамарсан халдварт цар тахлын улмаас БНХАУ, ОХУ зэрэг дэлхийн улс орнууд хилээ хаах хүртэл арга хэмжээ авч, онцгой дэглэм тогтоосон, материалын үнийн өсөлт болон тээвэр ложистикийн хүндрэлтэй асуудал үүссэн, Орос-Украины дайны улмаас барууны орнууд ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг тавьж, Европт эрчим хүчний хямрал нүүрлэсэн, инфляцыг дагаад үнийн хөөргөдөл бий болсон зэрэг давагдашгүй хүчин зүйл, түүний сөрөг үр дагавар нь 2023 онд ч нөлөөлсөн нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хувьд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн саад, хүндрэл учруулсан. Гэвч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын уурхайчид, хамт олон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, шийдвэрт тусгагдсан бүтээн байгуулалт, томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн төлөө хичээн ажиллаж байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 54%, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 95%, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн /ӨНХ-ийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугам, Хам баяжуулалтын 12 сая тн/жил хүчин чадалтай 5-р секцийг шинэчлэх/ төслүүд 100% хийгдсэн ба одоо Баяжуулах үйлдвэрт 5 төсөл хэрэгжиж байна. Засварын механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон	70	УУБГ

						хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлж хүлээн авсан. Уг төслийн хүрээнд одоогийн Цутгуурын цехийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл хийгдэж байгаа бөгөөд Механик цехийн өргөтгөлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг барих болон шинэ Цутгуурын цехийн барилга байгууламж, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн ажиллагаа явагдаж байна.		
4		2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологи	2020 - 2021	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100 хувьд хүрнэ. Олборлолтын зардлыг бууруулна.	Төслийн ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан "түлхүүр гардуулах" нөхцөлтэй гэрээний дагуу ХБНГУ-ын "ЗВТЕС Aufbereitung ssysteme GmbH" ХХК-ийн гүйцэтгэж байна. Гэрээний үнэ: 40.7 сая ам.доллар, гэрээний хугацаа: 2021.11.28 байсан. Гүйцэтгэгч компанийн зүгээс цар тахал, хил хаагдсан болон тээвэр ложистикийн хүндрэлтэй асуудал зэргээс төслийн ажил графикт хугацаанаасаа ихээхэн хоцорсон тул гэрээний хугацааг сунгах, мөн Орос-Украины дайн, Европ дахь эрчим хүчний хямрал, инфляци зэрэг хүчин зүйлийн улмаас үнэ өссөн гэсэн үндэслэлээр гэрээний үнийг 48 хувиар нэмэгдүүлж, 59.7 сая ам.доллар болгох хүсэлтийг удаа дараа тавьсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын зүгээс төслийн үнийн дүнг их хэмжээгээр нэмэгдүүлэх гүйцэтгэгчийн санал бодитой эсэхэд хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтийг тендерт шалгарсан олон улсын аудитын "Кей Пи Эм Жи Аудит" ХХК-иар гаргуулсан. "Кей Пи Эм Жи Аудит" ХХК-ийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгч компаниатай хэлцэл хийж, 2023.07.21-нд гэрээний нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Үүнд: гэрээний хугацааг 2025.07.30 хүртэл сунгаж,	50	УУБГ

						гэрээний үнийг 52.67 сая ам.доллараар тохиролцсон. Мөн 2024.07.20-ыг хүртэл хийгдэх ажлын календарчилсан төлөвлөгөөг баталсан. Төслийн ажил гэрээний нэмэлт, өөрчлөлт, календарчилсан төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Нийт гүйцэтгэл: 54%		
5		2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр.	2019-2020	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100%.	Төслийн ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан "түлхүүр гардуулах" нөхцөлтэй гэрээний дагуу "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК гүйцэтгэж байна. Гэрээний үнэ: 10.2 тэрбум төгрөг, гэрээний хугацаа: 2022.04.30 байсан. Цар тахлын халдварын дэгдэлтээс шалтгаалан давагдашгүй хүчин зүйл үүссэн, БНХАУ-ын хил хаагдсан, тээвэрлэлт саатсан, материалын үнэ өссөн зэргээс шалтгаалан хугацаа их алдсан гэх үндэслэлээр гүйцэтгэгч компанийн тавьсан удаа дараагийн хүсэлтийн дагуу төслийн ашиглалтад оруулах хугацааг 2023.06.30 хүртэл сунгасан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ажлын хэсэг уг төслийн ажилд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэж, зохих арга хэмжээ аван ажилласан боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан ажил удаашралтай явагдсан. Нийт төсөвт өртөг 2.11 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2023 оны эцэс гэхэд нийт 12.31 тэрбум төгрөгийн төлбөр хийсэн. Үүнд нэмэлт ажлын болон олон улсын аудитын "Кей Пи Эм Жи Аудит" ХХК-ийн дүгнэлтийн дагуу төсөв нэмэгдсэн. 2023.12.13-нд Улсын комисс ажиллаж, үйлдвэрийн барилгыг хүлээн авсан. Шинэ Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрт 2024 оны 3-р сард туршилтын журмаар нийт 55 тн тэсрэх бодис үйлдвэрлэсэн. Тэсэлгээний улсын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарах, хөндлөнгийн экспертизийн дүгнэлт гарах, барилгын агаар сэлгэлтийн	90	УУБГ

						хөдөлгүүрүүд болон шугам хоолой суурилуулах ажлуудыг гүйцэтгэж байна. Нийт гүйцэтгэл: 95%			
6		2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл	2020 - 2023	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	15,649.0 сая.төг	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100 хувьд хүрнэ.	<p>1. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжинд ӨНХ-ийн жилд 6 сая тонн хүдэр боловсруулах 4-р шинэ шугамыг барьж байгуулах төслийг 2019-2022 онд хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын Jiangxi Naipu mining machinery компани ажилласан бөгөөд төслийг хэрэгжүүлснээр Баяжуулах үйлдвэрийн боловсруулах хүчин чадал 38 сая тн болсон. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл, шинэчлэлийн дараагийн шатанд ӨНХ-ийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугамын хүчин чадлыг 2.0 сая тн-р өргөтгөх төсөл хэрэгжиж байна. Төсөл 2024 онд дуусна. Ажлын зураг төслийг боловсруулан экспертизээр баталгаажуулсан. Төслийн хүрээнд өргөтгөлийн МШЦ 6.71x9.75 маркийн №9 тээрэм суурилуулах ажлыг тендерт шалгарсан БНХАУ-ын Jiangxi Naipu mining machinery компани 2023 оны 1 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байна. Үндсэн тоног төхөөрөмж болох тээрэм, түүний иж бүрдлүүдийн үйлдвэрлэл дуусаж, хяналтын угсралт хийгдсэн бөгөөд үндсэн тоног төхөөрөмжүүд 95%, цахилгаан хэрэгсэл 90% нийлүүлэгдэж, суурилуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Нийт ажил 65%-ийн гүйцэтгэлтэй байна. Энэхүү өргөтгөлийг хийснээр Эрдэнэт үйлдвэр нь жилд 40 сая тонн хүдэр боловсруулах зорилтод хүрэх юм.</p> <p>2. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд эхний ээлжинд хам баяжуулалтын 5-р секцийг шинэчилсэн бол үргэлжлүүлэн хам баяжуулалтын жилд 12 сая тн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 2, 3-р секцийг шинэчлэх</p>	50	УУБГ

						<p>төслийг хэрэгжүүлж байна. Төслийг 2024 онд дуусгахаар ажиллаж байна. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад FLSmidth Mongolia компани шалгарч, 2023 оны 5 дугаар сард гэрээ байгуулсан. Төслийн ажил гэрээ, төлөвлөгөөний дагуу хэвийн явж байна. Нийт төслийн гүйцэтгэл 54%. Энэхүү төсөл нь Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадал жилийн 40 сая тн хүрч нэмэгдэх үеийн хөвүүлэн баяжуулалтын дамжлагын технологийн найдвартай ажиллагааг хангах зорилготой.</p> <p>3. Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх ажлыг 2023-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. ТЭЗҮ, ажлын зураг төслийг “Соёолон интернэшнл” ХХК боловсруулж, 2023.10.06-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-ийн хурлаар хэлэлцүүлж, хамгаалсан. Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх ажил нь 2 хэсгээс бүрдэж байна. Үүнд: Эхний хэсэг болох “Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажил” нь 3 багцтай. 2023 оны 11 дүгээр сард зарласан 1-р багц буюу “Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, шефмонтаж, тохируулгын ажил”-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад “Оремтрейд” ХХК шалгарч, 2023.12.25-ны өдөр гэрээ байгуулсан. 2-р багц буюу “Цахилгааны ажил”, 3-р багц буюу “Барилгын ажил”-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэж байна.</p> <p>Хоёрдахь хэсэг болох “Өндөр даралтын булт нунтаглагчийг нэвтрүүлэх ажил” нь мөн 3 багцтай. 2023 оны 11 дүгээр сард зарласан 1-р багц буюу “Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, шефмонтаж, тохируулгын ажил”-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад “ФЛСмидт Монголиа” ХХК шалгарч, 2024.01.29-ны</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						<p>өдөр гэрээ байгуулсан. Харин 2-р багц буюу "Цахилгааны ажил", 3-р багц буюу "Барилгын ажил"-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэж байна.</p> <p>4. Баяжуулах үйлдвэрт хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажлыг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. ТЭЗҮ-ийг 2022 онд "Хайдродизайн" ХХК гүйцэтгэж, ЭБМЗ-д хамгаалсан. Хаягдал өтгөрүүлэх технологийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, инженер геологийн судалгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг тендерт шалгарсан "Соёолон интернэшнл" ХХК 2023 оны 1 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байна. Ажил гэрээ, графикийн дагуу явж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 96 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>5. Хаягдлын шинэ сан барих ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерт Австрали улсын АТС Williams компани шалгарч, 2023.10.24-ний өдөр гэрээ байгуулсан. Ажил гэрээ, графикийн дагуу явагдаж байна. Засгийн газрын 2024.03.20-ны өдрийн 116-р тогтоолоор Булган аймгийн Орхон сум, Орхон аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн хаягдлын шинэ санг байгуулах зориулалтаар ашиглах нийт 7046.15 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Хаягдлын шинэ сангийн бүтээн байгуулалтын ажил 2028 онд дуусч, ашиглалтад орох юм.</p>			
7		2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл	2020 - 2024	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	-	Засварын механикийн заводын өргөтгөл,	Засвар, механикийн заводыг хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төслийн ажлыг "Ди Ди Эй Жи" ХХК гүйцэтгэж, 2022.08.18-нд ЭБМЗ-	30	УУБГ

					шинэчлэл 100 хувьд хүрнэ.	<p>ийн Боловсруулах үйлдвэрийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн.</p> <p>ТЭЗҮ-ийн дагуу:</p> <p>1. Одоо ажиллаж байгаа Цутгуурын цехийг өргөтгөж, жилд 5200 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг 7000 тн болгон нэмэгдүүлэх,</p> <p>2. Одоо ажиллаж байгаа Механик цехийн өргөтгөл, шинэчлэлээр 3300 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг 5900 тн болгож нэмэгдүүлэх бөгөөд резин эдлэлийн үйлдвэрлэлийн хэмжээг 2030 он хүртэл 750 гаруй тн хүртэл өсгөн нэмэгдүүлж, уг хэсгийг өргөтгөн, шинэ барилга байгууламж барьж, техник, технологийг бүхэлд нь шинэчлэх,</p> <p>3. Шинэ төрлийн элэгдэлд тэсвэртэй хром-молибдент гангаар хагас өөрөө нунтаглах SAG тээрмийн импортоор худалдан авч буй хуягийг үйлдвэрлэх зорилгоор жилд 7000 тн цутгамал бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ Цутгуурын цехийн төслийг хэрэгжүүлэх зэрэг чиглэлүүдээр хөрөнгө оруулалтыг тооцож төлөвлөсөн.</p> <p>ТЭЗҮ-ийн дагуу дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:</p> <p>1/ Цутгуурын цехийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, шинэчлэлийн барилга байгууламжийг барих ажлыг тендерт шалгарсан "Аглут" ХХК гүйцэтгэж байна. 2024.06.01-ний өдрийн байдлаар гүйцэтгэл 70%-тай байна.</p> <p>2/ Механик цехийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төслийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Резин эдлэлийн үйлдвэрлэлийн өргөтгөлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц барих ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийг 2023 онд 4 удаа зарласан боловч амжилтгүй болсон. Сонгон шалгаруулалтыг 2024 оны 04</p>		
--	--	--	--	--	---------------------------	---	--	--

						<p>дүгээр сард дахин зарласан. ШӨХТГ-т гомдол гарч, 2024.06.01-ний өдрийн байдлаар хуулийн хүрээнд тендерийн ажиллагаа үргэлжилж байна.</p> <p>3/Шинэ Цутгуурын цехийн барилга байгууламж, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 2023 онд зарласан 3 удаагийн тендерийн ажиллагаа амжилтгүй болсон. Нээлттэй сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар ажиллаж байна.</p> <p>Мөн "Засвар механикийн завод-II" буюу Монгол улсын аж үйлдвэрийг хөгжүүлэх стратегийн хүрээнд машин үйлдвэрлэлийн кластер байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг 2023.08.24-ны өдөр байгуулсан гэрээний дагуу "Ди Ди Эй Жи" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 2024.06.01-ний өдрийн байдлаар 95%-тай. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн 2023.09.29-ний өдрийн шийдвэрээр байгуулагдсан Ажлын хэсэг ТЭЗҮ боловсруулах ажилд хяналт тавин ажиллаж байна.</p>		
8		3. Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна.	2021 - 2024	"МАК" ХХК, УУХҮЯ	250,384.6 сая төгрөг	<p>Бүтээн байгуулалтын ажил 100 хувьтай. Уулын баяжуулах үйлдвэр төслийн хүчин чадлаар ажиллана.</p> <p>Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 онд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна.</p> <p>Анхан бутлуурын хүчитгэсэн хананы угсралт дууссан, Барилга болон тоног төхөөрөмжийн суурийн цутгалт хийгдсэн.</p> <p>Барилгын металл хийц угсралтыг хийсэн. Үндсэн болон туслах тоног, материалын тээврийг хийж байна. Мөн туслах тоног төхөөрөмжийн захиалга, үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна.</p>	50	УУБГ

9	4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна.	2020 - 2024	"Шивээ-Овоо" ХК, УУХҮЯ, "Эрдэнэс Монгол" ХХК	4,364.5	"Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 71 хувьд хүргэнэ.	2021 онд "Шивээ-Овоо" ХК JBIC төслийн хүрээнд 14.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээгээр Комацу HD465 технологийн автомашин 5, Комацу PC-1250 гидро экскаватор 2 ширхэг нийлүүлэгдэж, эдгээр техникүүдийн төлбөрт 6.6 тэрбум төгрөгийг төлж, одоогийн байдлаар үлдэгдэл төлбөр 8.2 тэрбум төгрөг байна. 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар "Барловорлд Монголиа" ХХК-иас 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн гэрээтэй нийлүүлсэн CAT777E 2 ширхэг технологийн автомашины төлбөрт 6.8 тэрбум төгрөг төлж, үлдэгдэл төлбөр 1.1тэрбум төгрөг байна. Дээрх техникүүдийг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр технологийн автомашины шинэчлэл 30 хувийн биелэлттэй байна.	30	УУБГ
10	4.1. "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл.	2020 - 2021	"Багануур" ХК, УУХҮЯ, "Эрдэнэс Монгол" ХХК		"Багануур" ХК-ын ил уурхайн хүчин чадал 5.0 сая.тн-д хүрнэ.	Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн. Багануур ХК-ийн парк шинэчлэлт, уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 5.7 сая тоннд хүргэх санхүүжилтийг ЗГҮАХ-т 2 үе шаттай тусгасан. 2020 онд JBIC-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 29.8 тэрбум төгрөгийн 12 тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдсэн. 2021 онд 2-р шатны техникийн шинэчлэлд шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх ёстой боловч өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна.	30	УУБГ
11	4.2. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт	2020 - 2024	"Шивээ-Овоо" ХК, УУХҮЯ, "Эрдэнэс Монгол" ХХК	4,364.5	"Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 71 хувьд хүргэнэ.	2021 онд "Шивээ-Овоо" ХК JBIC төслийн хүрээнд 14.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээгээр Комацу HD465 технологийн автомашин 5, Комацу PC-1250 гидро экскаватор 2 ширхэг нийлүүлэгдэж, эдгээр техникүүдийн төлбөрт 6.6 тэрбум төгрөгийг төлж, одоогийн байдлаар үлдэгдэл төлбөр 8.2 тэрбум төгрөг байна. 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар "Барловорлд Монголиа" ХХК-иас 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн гэрээтэй нийлүүлсэн	50	УУБГ

							CAT777E 2 ширхэг технологийн автомашины төлбөрт 6.8 тэрбум төгрөг төлж, үлдэгдэл төлбөр 1.1тэрбум төгрөг байна. Дээрх техникүүдийг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр технологийн автомашины шинэчлэл 30 хувийн биелэлттэй байна.		
12		5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	1,000.0	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 100 хувь.	“Эрдэнэс Монгол” ХХК Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн №48 тогтоолоор Асгатын мөнгөний ордод ордын геолги хайгуулын ажлыг гүйцэтгэх, уул техникийн нөхцөл тодорхойлох, уурхайн баримт материалын зураг боловсруулах, нөөцийн тайлан, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулж үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлох чиг үүрэг бүхий “Асгат төслийн нэгж”-ийг байгуулсан. Асгат төслийн нэгжийн бүрэлдэхүүн 2023 оны 8 дугаар сарын 1-ээс ажлаа эхэлсэн. Асгатын мөнгөний ордын техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах ажилд “Эрдэнэс Монгол” ХХК 2023 оны төсөвт Асгатын мөнгөний ордыг ашиглах, олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад холбогдох үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 11,090,452,828 төгрөг тусгасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч компани нь зам засах ажлаа эхлүүлсэн. Нийт 45км зам засварын ажил хийхээс 40км зам засварын ажлыг хийж гүйцэтгээд байна. • Асгатын ордын уурхайн амнуудыг нээх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. 6-р сарын 20-оос ам нээх ажлуудыг эхлүүлээд байна. 	30	УУБГ

						<ul style="list-style-type: none"> • Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. • Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Уг компани нь 6-р сард ажлаа эхлүүлэн гэрээний дагуу эхний 30 хувийн гүйцэтгэлийн тайлангаа ирүүлээд байна. <p>Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /jorc/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах ажлын тендер шалгаруулалтыг ТХААГазраас зарлан 2024.02.26-ний өдөр нээлт хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн боловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газар дахин нээлтэй тендер шалгаруулалтыг аргаар 2024.04.19-ны өдөр нээлт хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн боловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 05 дугаар сарын 03-нд дахин тендерийг зарлаад 5-р сарын 29-ны өдрийн үнэлгээний хорооны шийдвэрээр эхний ээлжид ажил гүйцэтгэх компани шалгарсан. Тус шалгарсан компанитай 6-р сарын 10-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд тус компани нь ордод хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

13		5.1. Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалт.	2020 - 2021	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	-	Лабораторийн туршилт хийлгэх ажил 100 хувь	Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15 (Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Туршилт судалгааны ажилд ирүүлсэн дээж нь ордыг төлөөлөхгүй байна гэж дахин дээж авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах 3Г-н чиглэлийн дагуу цуцлагдсан.	30	УУБГ
14		5.2. Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт.	2020 - 2022	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	-	Зөвлөх үйлчилгээний ХО 100 хувь	Компанийн 2020-2022 оны төсөв 150 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас уг тендер зарлагдаагүй.	0	УУБГ
15		5.3. Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт	2021 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	1000.0	Нэмэлт хайгуулын ажлыг дуусгах, хөрөнгө оруулалтыг 100 хувьд хүргэнэ.	"Эрдэнэс Монгол" ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилтын ажил хийж Ордын нөөцийг баталгаажуулахаар 2024 оны төсөвт 9,182,096,276 төгрөг тусгасан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас дахин 2024 оны 05 дугаар сарын 03-нд зарлаад 5-р сарын 29-ны өдрийн үнэлгээний хорооны шийдвэрээр гүйцэтгэгч компани шалгарсан. Тус шалгарсан компанитай 6-р сарын 10-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд тус компани нь ордод хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.	30	УУБГ

16		5.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт.	2021-2023	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	-	Дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт 100 хувь	<p>Өмнөх судалгааны ажлын явцад хийгдсэн Хэвтээ ам-1, Хэвтээ ам-1а, Хэвтээ ам-2, Хэвтээ ам-3, Хэвтээ ам-4, Хэвтээ ам-5-уудыг ашиглах боломжийг хангах, нарийвчилсан хайгуулын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах тендерүүдийг зарласан:</p> <ul style="list-style-type: none"> - ЭМГЛ/202306084 дугаартай "Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах" тендерийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч компани нь зам засах ажлаа эхлүүлсэн. - ЭМГЛ/202306085 дугаартай "Асгатын ордын уурхайн хэвтээ ам нээх" тендерийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Ам нээх ажлуудыг гэрээний дагуу 6-р сарын 20-оос эхлүүлээд байна. - ЭМГЛ/202306088 дугаартай "Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын гурван хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. - ЭМГЛ/202306087 дугаартай "Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн зөвлөх" үйлчилгээний ажилд шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Уг компани нь 6-р сард ажлаа эхлүүлсэн бөгөөд гэрээний дагуу 30 хувийн гүйцэтгэлтэй эхний тайлангаа ирүүлээд байна. 	30	УУБГ
17		6.Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах	2021 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	423,946.7 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах	<p>6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт- 36%</p> <p>6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт- 34%</p> <p>6.3. 3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр- 81.5%</p> <p>6.4. 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах- 96.3%</p> <p>6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх- 98%</p>	70	УУБГ

		үйлдвэрийг ашиглалтад оруулна.				үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 90 хувь			
18		6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт	2020 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	58,327.6	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 21 хувь	<p>2024 оны 06-р сарын 25-ний байдлаар 16 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэх хүчин чадалтай дараах техникүүдийг хүлээн авсан.Үүнд:</p> <p>Экскаватор</p> <ul style="list-style-type: none"> • Liebherr 9600/36 м3/ - 1 ширхэг экскаватор, • Liebherr 9250/16 м3/ - 2 ширхэг экскаватор, • Liebherr 9200/12 м3/ - 2 ширхэг экскаватор, • Liebherr 9100/7м3/- 2 ширхэг • XCMG XDE2000/11 м3/ - 1 ширхэг • Liebherr 9400/угсралтын ажил хийгдэж байна./ • Liebherr 9400/угсралтын ажил хийгдэж байна./ • Liebherr 9250/угсралтын ажил хийгдэж байна./ <p>Автосамосвал</p> <ul style="list-style-type: none"> • Белаз 75135 /130 тонн/ - 12 ширхэг • XCMG XDE130/120 тонн/ - 9 ширхэг • XCMG XDE240/230 тонн/ - 14 ширхэг • XCMG XDE240/230 тонн/ - 11 ширхэг/Үзлэг хийгдсэн хүлээлгэн өгөхөд бэлдэж байна./ • XCMG XDE130- 12 ширхэг /2024 оны 02-р улиралд нэмэгдэнэ./ • XCMG XDE240- 5 ширхэг /2024 оны 02-р улиралд нэмэгдэнэ./ • XCMG 230-260тн- 14 ширхэг /2024 оны 02-р улиралд нэмэгдэнэ./ <p>Бульдозер</p> <ul style="list-style-type: none"> • CATD8 – 1 ширхэг • Liebherr PR764 - 1 ширхэг • Liebherr PR-776 - 5 ширхэг <p>Автогрейдер</p>	30	УУБГ

							<ul style="list-style-type: none"> • CAT14 - 1 ширхэг • XCMG GTR3505 - 2 ширхэг • XCMG GTR3505 - 4 ширхэг /угсралтын ажил хийгдэж байна./ <p>Дугуйт түрэгч</p> <ul style="list-style-type: none"> • Белаз 78231 - 1 ширхэг. <p>2024 оны 2 дугаар улиралд багтааж үлдсэн техник, тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авахаар, холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.</p>		
19	6.2.3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт	2021 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	163,034.5	Цанхийн баруун уурхайн хөрсний конвейерийн систем нэвтрүүлэлт 79 хувь	<p>Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан 2023.09.12-ны өдөр ЭБМЗ-р хэлэлцүүлж, СТР/23-05-01 дугаарт зөвлөмжөөр баталгаажуулсан. 2023.12.01-ний өдөр "Эрдэнэс Монгол" нэгдлийн техник, технологийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-н үндэслэлийг хэлэлцүүлсэн.</p> <p>Төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн ЭТТХК/202310502 дугаарт тендерийг 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр тендерийг нээн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Xinjiang Coal Design and Research Institute" компанитай 04 дүгээр сарын 04-ний өдөр ЭТТ-2024/993 дугаарт гэрээг байгуулсан.</p> <p>Зураг төсөл боловсруулалт ажил эхэлсэн байна.</p>	30	УУБГ	
20	6.3.3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	2023 онд 149.09 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулийн бүтээн байгуулалтын ажил 100%-д хүргэнэ.	<p>2024 оны 06-р сарын 25-ны байдлаар том объектууд угсрагдсан, нийт угсралтын ажил жигдэрч, туршилтын ажлууд хийгдсэн. Төслийн зургаан багц ажлын хүрээнд гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:</p> <p>Багц 1 100% (вагонд ачигч), Багц 2 100% (Бутлуур), Багц 3 100% (Туузан дамжуурга, дагалдах тоног төхөөрөмж), Багц 4 98.9% (Овоологч, тэжээгч),</p>	90	УУБГ	

							Багц 5 100% (Барилга байгууламж, зам талбай), Багц 6 99.8% (Эрчим хүч, автоматжуулалт) гүйцэтгэлтэй байна.		
21		6.4. 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах.	2021 - 2022	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	-	Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 100%-д хүргэнэ.	2024 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар ТНАЛТ буюу Ачилтын нэгдсэн төвийн том объектууд угсрагдсан бөгөөд нийт угсралтын ажил жигдэрч, 6 багц ажлын гүйцэтгэл тус бүр 92%-иас дээш байна. Одоогоор Дуут дохио, мэдрэгч суурилуулах болон "belt drift" суурилуулж холбох ажлууд явагдаж байна.	90	УУБГ
22		6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ УУБГ	96,162.2	Усан хангамжийн хөрөнгө оруулалт 100 хувьд хүргэх	-Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн Цахилгаан хангамжийн техникийн комиссыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан бүрэлдэхүүнээр ажиллуулж холбогдох үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан. -Үүрэг даалгаврын дагуу ажлыг дуусган ЦДАШ-ын хэсэгт улсын комисс ажиллуулах хүсэлтийг ЭХЯ-нд хүргүүлсэн. -Усны гүний худаг, ус цуглуулах шугам, гол шугам хоолой, өргөх насос станцуудыг шалган туршилт хийн ус дамжуулах хоолойнуудыг угаан 1500 м3-ийн усан сангуудыг усаар дүүргэсэн. Туршилт тохируулгыг үргэлжлүүлэн хийж байна.	90	УУБГ
23	3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.	2021 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэс силвер ресурс" ХХК	-	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэнэ.	2024 оны 6 дугаар сард 223.7 мян.м3 уулын цул хөдөлгөж 89%-ийн гүйцэтгэлтэй, 186.8 мян.м3 хөрс хуулж 81%-ийн гүйцэтгэлтэй, 65.6 мян.тн хүдэр олборлож 84%-ийн гүйцэтгэлтэй, 44.2 мян.тн хүдэр боловсруулж 77%-ийн гүйцэтгэлтэй, 0.8 мян.тн баяжмал үйлдвэрлэж 70%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.	100	УУБГ
24		2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.	2021 - 2024	УУХҮЯ, Монголросцветмет ТӨҮГ	-	-	2021 оны 8-р сараас Зүүн цагаан дэлийн далд уурхайн үйл ажиллагааг эхлүүлэн, 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн.	100	УУБГ

							<p>2021 оны 8-р сараас Зүүн цагаан дэлийн далд уурхайн үйл ажиллагааг эхлүүлэн, 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн 2022 оны 09-р сарын 28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн.</p> <p>2021 оноос 2023 оны хооронд уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба. Ажилчдын амрах 108 хүний 2 кэмгийн барилга байгууламжийн ажил бүрэн баригдаж дуусан одоо ашиглаж байна.</p> <p>Уурхайн нэвтрэлтийн ажлын гүйцэтгэл 2021 оноос одоог хүртэл төлөвлөгөөт графикын дагуу 100% гүйцэтгэлтэй байна. +1140 түвшингээс ЦНС-105 маркийн 2 ш ус шахуургаар далд уурхайн шүүрлийн ус соруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.</p> <p>Бор-Өндөр УБҮ-н тэсэлгээний тусгай зөвшөөрөл сунгах зөвлөлийн хурлаар 2024 оны 1-р сарын 5-ны өдөр орж 100%-н дэмжлэгтэйгээр 5-н жилээр сунгах дүгнэлт гарсан. Сайдын тушаал 1-р сарын 26-ны өдөр гарч, 2024 оны хяналтын хуудас 2024 оны 2-р сарын 8-ны өдөр гарсан. Зүүн цагаан дэлийн үйл ажиллагааг 2024 оны 1-р сарын 1-с эхлэн түр зогсоогоод байсан бөгөөд 2024 оны 2-р сарын 13-ны өдрөөс нэвтрэлтийн ажлыг эхлүүлсэн. 2024 оны 3-р сард +1150 түвшинд 7-р хүдрийн биетийг нээх бэлтгэл малталтын ажлыг хийж гүйцэтгэж байна. 4-р сард +1150 түвшинд 7-р хүдрийн биетэд дэд давхаргын штрек болон агааржуулалтын босоо малталтын нэвтрэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. 5-р сард 76.1у.м/514.3м3 нэвтрэлтийн ажил төлөвлөснөөс 83у.м/594.2м3 хийж гүйцэтгэсэн.</p>		
25	3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны	1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг	2021 - 2024	УУХҮЯ, УГА, ААНБ	Улсын төсөв Батлагдсан: 3,500.1 2024 гүйцэтгэл:	Нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг баталсан.	50	ГБГ

	ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна			1427.3 Санхүүжилт 1022.3	20 талбай ялгана.	<p>2. Дөч гол-50, Халзан овоо-50, Өндөр ширээт-50, Хайрхан овоо-50, Үнэгт уул-50, Цэцэрлэг-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50 төслүүдийн үр дүнгийн тайланг 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн УТХ-2024-04, УТХ-2024-05, УТХ-2024-06 хурлаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн 46.9%-ийг хамруулсан.</p> <p>3. Үргэлжлэн хэрэгжиж буй Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 төслүүдийн 2024 оны төсөв, төлөвлөгөөний тодотголыг ЭБМЗ-ийн УТХ-2024-01, УТХ-2024-02, УТХ-2024-03 дугаар хуралдаанаар хэлэлцсэн. Хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын шийдвэрийн төслийг боловсруулсан.</p> <p>4. Бөөн хөх уул-50, Индэртийн нуруу-50, Цагаан овоо-50 төслүүдийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажлын явцад шуурхай хяналтыг хийсэн.</p> <p>5. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх Дарьганга-50, Буйр нуур-50, Хавирга-50, Эрдэнэцагаан-50, Номингийн говь-50, Боршоо-50 төслүүдийн холбогдох судалгаа, төсвийн тооцооллыг хянаж 2025 оны төсвийн саналыг боловсруулан нэгтгэж холбогдох хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>6. Дэвийн хонгор уул-50 төслийн ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнэсэн.</p>		
26		2:1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн	2022 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 17,500.0 2024 төсөв: -	Нутаг дэвсгэрийн 0.15%-д судалгааны ажлыг гүйцэтгэнэ.	"1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаардлага"-ын заавар боловсруулах ажлыг Үндэсний геологийн албатай хамтран хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд тус албаны даргын 2024 оны А/27 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан.	0	ГБГ

		0.15 хувийг хамруулна							
27		3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна	2021 - 2023	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 3,515.2 Төсөв: - Гүйцэтгэл:	L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 100%-ийг бүрхэх, үр дүнг хүлээн авна.	1. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох "УГЗ-200-Д-VII" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-2024-05 дугаар хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар 2002 оноос хэрэгжүүлж эхэлсэн зураг зохиох ажил бүрэн хэрэгжсэн. 2. Монгол орны нутаг дэвсгэрт хийгдсэн Улсын геологийн зургийг нэгтгэх ажлын хүрээнд L хавтгайн хэмжээнд буюу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Төв, Булган, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын ихэнх нутгийг хамарсан нийт 839,481.26 кв.км талбайд зохиогдсон Улсын геологийн 1:200000 масштабын иж бүрдэл зургуудыг нэгтгэх "УГЗ-200-нэгтгэл-Л" төслийн үр дүнг Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянаж, шүүмжлэгч томилон ажиллуулж байна. 3. Мөн M (N) хавтгайн хэмжээнд буюу 2020-2023 онд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв, Хэнтий, Дорнод аймгуудын ихэнх нутгийг хамарсан 504,222.97 кв.км талбайд гүйцэтгэсэн "УГЗ-200-М-200" төслийн үр дүнг Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянаж, шүүмжлэгч томилон ажиллуулж байна.	70	ГБГ
28		4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 5,406.1 Төсөв: 30,268.3 Гүйцэтгэл: -	Ховд-2020 төслийн үр дүнг хүлээн авах, нутаг дэвсгэрийн 66.6%-ийг хамруулах, Хангай-1	1. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай Ховд-2020 төслийн судалгааны ажлаар: -Нийлбэр соронзон орны эрчимжилтийн зураг, -Туйлын засвар хийсэн нийлбэр соронзон орны зураг, -Нийлбэр цацраг идэвхжилийн зураг (Tcnt), -Газрын калийн агуулгын зураг (K),	90	ГБГ

		70 хувийг хамруулна			Санхүүжилт -	төслийг эхлүүлнэ.	-Газрын тори-ийн агуулгын зураг (Th), -Газрын ураны агуулгын зураг (U) зэрэг нийт 6 төрлийн зургийг 104,044 кв.км талбайн хэмжээнд тайлбар бичгийн хамт зохиогдож, үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн УТХ-2024-04 хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол орны нутаг дэвсгэрийн 66.6%-ийг хамруулсан. 2. Монгол орны Өмнөд бүсийг хамарсан Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизик-2024" төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг УГА-тай хамтран зохион байгуулсан. Тендерт шалгарсан "Геологийн судалгаа, шинжилгээний төв" ТӨҮГ, XCalibur компанийн түншлэлтэй ажил гүйцэтгэх гэрээг 2024.05.08-ны өдөр байгуулан ажлыг эхлүүлсэн.		
29		5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна	2021 - 2022	УУХҮЯ, УГА, ААНБ	Нийт хөрөнгө: 1,258.1 Төсөв: - Гүйцэтгэл: -	Нутаг дэвсгэрийн 100%-д Геохими-2019 судалгааны ажлыг хийж дуусган, үр дүнд хүлээн авах.	Монгол орны нутагт 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:1000000-ын масштабтай геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх төслийн ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабтай геохимийн зураглалд бүрэн хамруулсан.	90	ГБГ
30		6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ, УГА, ААНБ	Нийт хөрөнгө: 7,708.8 2024 төсөв: - 2024 гүйцэтгэл: - Санхүүжилт -	Дархан хотын судалгааны үр дүнд хүлээн авах, Чойбалсан, Ховд, Даланзадгад хот, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг үргэлжлүүлэх, Шаргалжуут геотермийн	1. "Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа" төслийн үр дүнгийн тайланг 2023 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024.04.19-ний өдрийн А/110 дугаар тушаалаар төслийн үр дүнд хүлээн авч шийдвэрлэсэн. 2. Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа" төслийн үр дүнгийн тайланг 2023 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024.04.19-ний өдрийн А/103 дугаар	70	ГБГ

						судалгааг эхэлнэ.	тушаалаар төслийн үр дүнг хүлээн авч шийдвэрлэсэн. 3. Ховд хотын суурьшлийн бүсийн хэмжээнд 2021-2023 онд гүйцэтгэсэн геозкологи-гидрогеологийн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024.03.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. 4. Дархан хотын суурьшлийн бүсийн хэмжээнд 2021-2023 онд гүйцэтгэсэн геозкологи-гидрогеологийн судалгааны болон Монгол орны төв, хойт бүсийн 602,984.0 км ² талбайн хэмжээнд гүйцэтгэсэн Гүний хагарал төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		
31		7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 18,000.0 Төсөв: 2,638.5 Гүйцэтгэл: 1,416.1 Санхүүжилт 920.4	Тек-2021, ТЗ-2021, ЭТЭ-2022 төслийг үргэлжлүүлэх, геофизикийн трансект ГеофТ-200, Геохими-200 төслийг ажлыг эхлүүлнэ.	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх судалгааны ажлуудын төсөв, төлөвлөгөөг хуваарилан баталсан. Үүнд: 1.1. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх Геологийн орчин-2022 төслийн суурин боловсруулалтын ажлын төлөвлөгөө, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар 2024 онд хэлэлцсэн. 1.2. Ханбогдын дүүрэгт гүйцэтгэх геохимийн Ханбогд геохими-2023 судалгааны ажил төслийн завсрын суурин боловсруулалтын ажлын төлөвлөгөө, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар 2024 онд хэлэлцсэн. 1.3. Ханбогдын дүүрэгт гүйцэтгэх геофизикийн соронзон судалгааны Ханбогд соронзон-2023 ажлын төлөвлөгөө, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар 2024 онд хэлэлцсэн. 2. Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 05 сарын 22-ны өдөр баталсан шуурхай хяналтын удирдамжийн дагуу Геологийн	70	ГБГ

							орчин-2022, Ханбогд геохими-2023, Ханбогд соронзон-2023 төслийн үр дүнгийн тайлан боловсруулалтын явц, үр дүнд шуурхай хяналт хийсэн.		
32		8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 6,500.0 Төсөв: - Гүйцэтгэл: - Санхүүжилт: -	ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлын үр дүнг хүлээн авах, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлнэ.	Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан “Хойт,Төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн 5-р үе шатны “Төв Ази 3D 5-р шат” ажлын 2021-2023 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.	90	ГБГ
33	3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 2,000.0 Төсөв: 376.2 Гүйцэтгэл: 299.5 Санхүүжилт 254.6	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 100%	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх “Геологийн баримт-1-2022” ажлын төсөв, төлөвлөгөөг баталсан. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн тус төслийн завсрын суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. Үүнд: 1. ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар 2024 оны төсөл, төсвийн тодотголыг хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн дүгнэлтэд үндэслэн тухайн төслийн төсвийн тодотголыг батлах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалын төслийг боловсруулан батлуулахаар удирдлагад танилцуулж байна. 2. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3808, Худаг-4575, Цооног-4317, Шлихийн хүрээ-2705, Өрөмдсөн цооног-400, Эрдэсжсэн цэг-155, Давхарга зүйн сан-457, Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-1914, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн	70	ГБГ

							олдворын дэд сан-2171, Үнэмлэхүй насны сан-1119, Нийтлэл-875. Үр дүн: Нийт 7160 мэдээллээр баяжуулсан.		
34		2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 2,000.0 Төсөв: 595.7 Гүйцэтгэл: 298.5 Санхүүжилт 235.4	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив бүрдүүлэх төслийг үргэлжүүлэх, ажлын явц 100%	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх “Цахим архив-1-2022”, “Чулуун дээжийн сан-1-2022” геологийн судалгааны ажлын төсвийг хуваарилан баталсан. 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн тус 2 төслийн завсрын суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. Үүнд: 1. “Цахим архив-1-2022”, “Чулуун дээжийн сан-1-2022” төслийн 2024 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтэд үндэслэн тухайн төслийн төсвийн тодотголыг батлах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалын төслийг боловсруулан батлуулахаар удирдлагад танилцуулж байна. 2. Чулуун сангийн агуулахад байгаа ордуудын дээжийг бүртгэх ажлын хүрээнд нийт 165 ордын чулуун дээж- 252, чөмгөн дээж-776, шлиф-621, аншлиф-318, технологийн дээж-6 ширхэг буюу 1973 ширхэг дээжийг бүртгэлжүүлсэн. 3. Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-2165, шлифийн-2700, аншлифийн-52 ширхэг фото зургийг авч мэдээллийн бичвэрийг хийсэн. Тайлангийн хавсралт материалаас 2736 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийж оруулсан. 4. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд 839 тайлангийн 1261 боть буюу 151,761 хуудас цахимжуулсан.	50	ГБГ
35	3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт,	1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 5,686.1 Төсөв: 698.3	ГХЭ-ийн төслийн үр дүнг хүлээн авах, өндөр технологийн түүхий эдийн	1. “Өндөр технологийн түүхий эд-1” төслийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар “Өндөр	50	ГБГ

	хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө			Гүйцэтгэл: 437.7 Санхүүжилт 363.9	судалгааг үргэлжлүүлнэ.	тенхологийн түүхий эд-2" төслийн 2024 оны төлөвлөгөө, төсвийг хуваарилан баталсан. 3. "Өндөр тенхологийн түүхий эд-2" төслийн суурин боловсруулалтын ажлын төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцсэн. ЭБМЗ-ийн дүгнэлтэд үндэслэн тухайн төслийн төсвийн тодотголыг батлах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалын төслийг боловсруулан батлуулахаар удирдлагад танилцуулж байна.		
36		2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө	2021 - 2024	УУХҮЯ, ҮГА, ААНБ	Нийт хөрөнгө: 39,325.1 Төсөв: 1,973.2 Гүйцэтгэл: 775.9 Санхүүжилт: 530.1	Өнгөт, хар металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлыг үргэлжлүүлэх, металл бус ашигт малтмалын судалгааг эхлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	1. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний "ЭҮ-1-2021" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023 оны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024.04.19-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар үр дүнг хүлээн авч шийдвэрлэсэн. 2. Монгол орны баруун, баруун өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийг тогтоох "БӨМ-Алт-2019" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023 оны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024.04.19-ний өдрийн А/105 дугаар тушаалаар үр дүнг хүлээн авч шийдвэрлэсэн. 3. "ЭҮ-2-2021", "ЭҮ-3-2021" төслүүдийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. 4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх "ЭҮ-4-2022", "Мета-алт-500", "БМШАМ-2022" судалгааны ажлын төлөвлөгөө, төсвийг хуваарилан баталсан. 5. "ЭҮ-4-2022" болон "Монгол орны алтны металлогени" /1:500000-ны масштаб/, өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны "Мета-алт-500", "БМШАМ-2022"	70	ГБГ

						ажлын төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар 2024 оны төсөл, төсвийн тодотголыг хэлэлцсэн. ЭБМЗ-ийн дүгнэлтэд үндэслэн тухайн төслийн төсвийн тодотголыг батлах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалын төслийг боловсруулан батлуулахаар удирдлагад танилцуулж байна.			
37		3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө.	2021 - 2024	УУХҮЯ, АМГТГ	60,000	Ашигт малтмалын хайгуулын 60-80 тусгай зөвшөөрөл шинээр олгон, хайгуулын ажлыг эрчимжүүлж геологийн нөөцийг өсгөнө.	Холбогдох хууль, журамд заасны дагуу www.tender.gov.mn платформ-оор сонгон шалгаруулалтыг зарлан тусгай зөвшөөрлийг олгож байгаа бөгөөд 5-р сард цахимаар сонгон шалгаруулалт зарлагдаагүй. Гүйцэтгэл: Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын байдлаар 69.412.89 мянган га талбайг хамарсан 71 талбайд хайгуулын малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлан үнэлгээ хийж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Улсын төсөвт 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.	100	ГБГ
38	3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно.	2020 - 2022	УУХҮЯ, АМГТГ	-	-	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг холбогдох хууль, журамд заасны дагуу www.tender.gov.mn платформ-оор сонгон шалгаруулж олон нийтэд нээлттэй болгосон. Нийт 69.412.89 мянган га талбайг хамарсан 71 талбайд хайгуулын малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Улсын төсөвт 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас	100	УУБГ, ГБГ

	болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.						2024 оны 05 дугаар сарын байдлаар 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Мөн түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгай зөвшөөрөл олголтын талаар нарийн зохицуулалтыг тусгаж өгсөн ба Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.		
39		2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ	2,500.0		Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг бий болгох талаар саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн. Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг хангаж байна.	30	УУБГ
40		3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, АМГТГ	818.6	-	Орон нутагт эрдэс баялгийн нэгж байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Өмнөговь, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон аймгуудад байгуулахаар "Зарим орон нутагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан бөгөөд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Сангийн яамны саналыг заавал авахаар буцаасан. Сангийн яамнаас "Нэр дурдсан аймгуудад байгуулах Эрдэс баялгийн хэлтсийг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газарт бус харин Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын харьяанд 2022 оноос эхлэн байгуулахаар тогтоолын төслийг өөрчлөх" гэсэн санал ирүүлсэн.	100	УУБГ

						Энэ саналтай уялдуулан Сангийн яам холбогдох орон тоо, төсвийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны төсөвт 1,0 тэрбум төгрөг тусгасан. Дээрх нөхцөл байдалд тохируулан Засгийн газрын тогтоолыг дахин боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022.04.11-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг асуудлыг 2022.08.03-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, Ашигт малтмал, газрын тосны газрын орон нутаг дахь төлөөлөгчийн газрууд бий болсон ба АМГТГ-ын орон тооны хязгаар 150 байсныг 185 хүнтэй болгосон талаар ЗГ-ын 295 дугаар тогтоол батлагдсан. АМГТГ уг ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах ажлыг зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор тусгаад байна.			
41		4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, АМГТГ, БСШУЯ, ХНХЯ	170.0	-	Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагад шилжүүлэн гэрээ байгуулан ажиллаж байна. 1. Гэрээний хугацаа 2024.04.09-ний өдөр дуусаж байгаатай холбогдуулан гэрээг дүгнэх, сунгах эсэхэд санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.03.21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай байгуулсан гэрээг 3 жилийн хугацаагаар сунгасан. 2. “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус	70	УУБГ, ГБГ

						байгууллагаар гүйцэтгүүлэх журам"-ын 2.2.8, 2.2.10 дахь заалт, УУХҮЯ болон МГХНЗ-ийн хооронд байгуулсан 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 20 дугаартай гэрээний 2.1.1 дэх заалтын дагуу МГХНЗ-өөс УУХҮЯ-тай хамтран 2024-2026 онуудад геологи, эрэл, хайгуул, геофизик, гидрогеологи, өрөмдлөг, геоэкологийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, албажуулсан.			
42	3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	1: Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, "Кью эс си" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК, ТӨХААГ, Холбогдох яамд	36,500.0	Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, барилгын ажлыг үргэлжлүүлнэ. 99.2%	"Эдийн Засаг Хөгжлийн Яам" /хуучнаар/ нь "Кью Эс Си" ХХК-тай 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан. 2020-2023 онуудад Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь гангийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННУ, Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоо, төслийн газар шорооны тэгшилгээний ажил, төмрийн хүдрийн туршилт, "Монгол ган цогцолбор I" төслийн 3D макет хийлгэх зэрэг нилээлгүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Толгой компани буюу "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.10.22-ны өдрийн "Чиглэл өгөх тухай" 01/836 дугаар албан бичгийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-д ирүүлсэн ба "Монгол ган цогцолбор I" төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай "Ган үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн тул өмнө хийгдсэн ТЭЗҮ, БОННУ, бусад судалгааны ажлуудыг 2024 онд шинэчлэн хийх шаардлагатай болсон. "Ган үйлдвэрлэлийн цогцолбор" төслийн хүрээнд мөн дээрх төслийг төмрийн хүдрийн түүхий эд болох хорголжоор	-	ХҮБГ

						<p>хангах зорилгоор Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төсөл болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гангийн үйлдвэрийн хүчин чадал ашиглалтыг 80% хүртэл нэмэгдүүлэх зорилгоор Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийг эхний шатанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төслийн судалгааны ажлуудыг хийлгэх бэлтгэл ажил /ажлын даалгавар боловсруулах г.м/-ууд хийгдэж байгаа ба нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төмрийн хүдрийн түүхий эдийн лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлэхээр 20 тн дээж бэлтгэн "Алтернатив металлурги" ХХК-д хүргүүлэн дээж бэлтгэлийн ажил хийгдэж урьдчилсан тайланг хүлээн авсан ба хөвүүлэн баяжуулах туршилтын ажлыг эхлүүлсэн.</p> <p>Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төслийн ТЭЗҮ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж бэлэн болгосон ба "Эрдэнэс Монгол" ХХК-д ТЭЗҮ-ийн ажлыг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл хүссэн албан бичиг явуулж, "Эрдэнэс ҮТП" ХХК-иар хийлгүүлэх чиглэлийг өгсөн. "Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр"-ийн төслийн ТЭЗҮ-ийг боловруулж ЭБМЗ-ийн 2024.06.24-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан.</p> <p>Мөн БНХАУ-ын "Бугатын ган төмөрлөгийн групп" компаниар төслийн концепцийн судалгааг хийлгэж хүлээн авсан.</p>		
43	2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2022	УУХҮЯ, "Бэрэн" ХХК, Холбогдох яамд	-	-	<p>Бэрэн групп ХХК-ны 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар,</p>	0	ХҮБГ

							нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй байгаа ба Хөгжлийн банкны зээл, өрийн асуудлаар "Бэрэн групп" ХХК-ийг хууль хяналтын байгууллагаас шалгаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон ба 2023 оныг дуустал хугацаанд (одоог хүртэл 2024.04.30) төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх талаар аливаа үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.		
44		3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.	2020 - 2023	УУХҮЯ, "МДМУ" ХХК, Холбогдох яамд	-	-	Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмж (нийт 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тус бүр нь 2 тн багтаамжтай 6 ш индукцийн зуух, дулаан боловсруулалтын 1 ш зуух дагалдах хэрэгслийн хамт)-ийн захиалга /БНХАУ "Qianxi ADI Mechanical Casting" Co.Ltd компанид/ хийгдэж, 2023 оны 10 дугаар сард татан авалтыг хийсэн ба угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн. 2024 оны 5 дугаар сарын байдлаар дулаан боловсруулалтын зуухны угсралтын ажил, цутгуурын цехийн төхөөрөмжийн угсралтын ажил 100 хувь хийгдсэн ба туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Мөн 6 кВ-ын 2.3 км /өмнөх техникийн нөхцөл өөрчлөгдөж 2.3 км-ээс татсан/ ЦДАШ-ыг барьж байгуулах ажлыг гүйцэтгэсэн. 128 м3 багтаамжтай домен зуухны захиалга хийгдэж, тоног төхөөрөмжийн татан авалт хийгдэж байна.	50	ХҮБГ
45		4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-	2020 - 2022	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	-	Дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн ҮТП-ийн төслийн нэгж 2024.03.18 өдрөөс эхлэн авто зам, төмөр замын гүйцэтгэгч, зураг төслийн гүйцэтгэгч, захиалагчын	30	ХҮБГ

		химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.				<p>хяналт тавих компаниудын төлөөлөлтэй холбогдох уулзалтыг зохион байгуулж, барилгын ажлыг үргэлжлүүлэх бэлтгэл ажлууд эхэлсэн.</p> <p>- ҮТП-ийн газар: Засгийн газрын "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮ-ийн яам, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн засаг дарга хооронд 2022.10.25-ны өдөр байгуулж, тус гэрээний дагуу ҮТП-ийн 2022.11.14-ны өдрийн №000000019 дугаартай Газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна.</p> <p>Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын эзэмших, ашиглах газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбицол тодорхойлох, шалгах ажил хийгдсэн, паркийн газрын 1:500 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг боловсруулсан.</p> <p>- ҮТП-ийн газрыг тойруулан хашаа барих: ажлын тендерт шалгарсан "Орчлон тулга" ХХК-тай 2022.12.05-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг "ЭҮ" ТӨҮГ байгуулсан бөгөөд нийт 16.3 км урттай хашаа баригдана. Гэрээний дагуу 90%-ийн санхүүжилт шилжсэн. Одоогоор 15 км баригдсан. Газрын хил хязгаар, дэд бүтцийн зураг төслийн давхцал үүсэж байгааг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна Гэрээний хугацаа сунгах шаардлагатай болсон тул гэрээг 2024.07.01-ний өдөр хүртэл сунгасан. /ажлын явц 92%/.</p> <p>- ҮТП-ийн авто зам: барьж байгуулах ажлын тендерийг 2022.06.30, 2022.09.26, 2022.11.07 зарласан, 3 дахь удаагийн тендерийг 2022.12.05-ны өдөр нээж</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>үнэлэхэд шаардлага хангасан материал ирүүлээгүй тул 2023.01.25-ны өдөр 4 дэх удаагийн тендерийг зарлаж 2022.02.23-ны өдөр нээсэн. Авто замын гэрэлтүүлэг барьж байгуулаг Багц-2 тендэрт "Орконтех" ХХК шалгарч, 2023.03.07-ны өдөр 7/004-23 тоот гэрээг байгуулсан. Гэрээний хугацаа 2024.11.01-нд дуусна. Автозамын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендэрт "Мөнхөд ашдын зам" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Багц-1 буюу Автозам барьж байгуулах ажлын тендер шалгарсан "Шилдэг зам" ХХК болон "ЭҮ" ТӨҮГ хооронд 2023.03.14-ны өдөр гэрээ байгуулсан (36% буюу 4,212.8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсэн), гэрээний хугацаа 2024.11.01-нд дуусна. Ажлын батлагдсан хуваарийн дагуу хэвийн үргэлжилж байна. /ажлын явц 41%/</p> <p>- ҮТП-ийн төмөр зам: барьж байгуулах ажлын тендерийг 2022.09.05, 2022.11.07-ны өдөр зарлаж, 2022.12.12-ны өдөр нээж, 2 дахь удаагийн тендэрт шалгарсан "Туулын гүүр далай" ХХК болон "ЭҮ" ТӨҮГ хооронд 2023.01.11-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан (69% буюу 9,791.8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсэн). Газар шорооны ажил 2023.04.09-өөс эхэлж өнөөдрийн байдлаар талбайд 38 хүн 40 техник хэрэгсэл 24 цагаар ажиллаж байна. Төмөр замын дэр бетоныг ажлын талбайд буулгасан. Ул хөрсний төлөвлөгдөөгүй нэмэлт ажил болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болж, гэрээг 2024.07.01 хүртэл сунгасан. Төмөр замын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендэрт "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК шалгарч, 2023.11.09-ний өдөр гэрээ байгуулагдсан. Гэрээний хугацаа 2023.07.30-нд дуусна. /Ажлын явц 87%/</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>- УТП-ийн ус хангамж, ариутгах татуургын систем: Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендерийг 2022 оны 05 дугаар сараас эхлэн зарласан боловч СЯ, ШӨХТГ-т гомдол гарах, тендер хүчингүй болох зэрэг шалтгаануудаар өнөөдрийг хүртэл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж чадаагүй байна. 2023.06.23-ны өдөр шүүх хурал болж, тендерт оролцогчийн гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэж, тендерийг дахин зарлах эрх зүйн байдал үүссэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг АУХААХ-с 2023.08.03-ны өдөр дахин зарласан боловч ШӨХТГ-т гомдол гарсан тул гомдлыг хянан шалгах үйл ажиллагаа үргэлжилж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарч "Б-софт" ХХК-тай 2023.12.13-нд гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2024.12.20-нд дуусна. Бохир усны Ф400мм голчтой ширмэн хоолой 790м, HDPE 110 мм голчтой 1570м, 250мм голчтой 3126м, нийт 5486 м шугамыг угсарч дууссан. Бохир усны Өргөлтийн насос станц №1,2,3,5 -ын суурийн газар шорооны ажил хийж суурийн бэлтгэл бетон суурь, ханын цутгалт, худгийн цутгалт хийсэн. Авто зам, төмөр замын 4 хэсэг газарт бохир усны 104м урттай шугамыг сүвлэж байрлуулсан. Цэвэр усны 300 мм 4350м урт цайрдсан ган хоолойг угсарч дууссан./ажлын явц 42%/.</p> <p>- УТП-ийн цахилгаан хангамжийн систем: УТП-ийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 2022.05 сард ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ, Диспетчерийн үндэсний төв горимын тооцоо зэргийг үндэслэн, ЭХЯ-наас УТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу 2022.10.28-ны өдөр цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						боловсруулан ирүүлсэн. Дээрх ажлыг "ЭҮ" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн болон "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ гүйцэтгэж байна. 220 кВ-ын дэд станц, ЦДАШ-ын зураг төслийн ажлын явц 90%, 110 кВ-ын дэд станц, ЦДАШ-ын зураг төслийн ажлын явц 100%, ҮТП-ийн цахилгаан хангамжийн системийн зураг төсөл боловсруулах ажлын нийт явц 95%.			
46		5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	2020 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ, Холбогдох яамд	325,680.0	Үйлдвэрийн барилгын угсралт, тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангана. 95%	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ)-ийн ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ нь БНХАУ "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Үйлдвэрийн ТЭЗҮ-ээр зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. - ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжаны Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Үйлдвэрлэлийн туршилтын хамтарсан гэрээний дагуу "ЭҮ" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэх ажлыг 2023.07.20-ны өдрөөс 2023.08.26-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан 2023.09.29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023.09.26-ны өдөр эхэлсэн ба туршилтын урьдчилсан үр дүнгээр үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд тодорхойлогдсон тул батлагдсан ТЭЗҮ-ийг шинэчлэн, тодотгол хийж холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮЯ-нд ирүүлээд байна.	30	ХҮБГ

						<p>- ЭБМЗ-өөс ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерийг 2022.11.02-нд нээж, "Эс Ай Си Эй" ХХК шалгарч, 2022.11.28-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгчээс ирүүлсэн эхний болон дундын тайланг "ЭҮ" ТӨҮГ-аас байгуулагдсан ажлын хэсэг хүлээж авсан. Олон улсын туршлагыг судалсан судалгааны үр дүнд үндэслэн үндэсний болгон батлуулах стандартуудыг хэлэлцэж, 4-н стандарт сонгосон. Одоогоор стандартуудын эх хувийг авах, орчуулах ажил эхэлсэн бөгөөд зөвлөх багаар хянагдаж байна. Энэ нь хугацаа их шаарддаг тул гэрээг 2025.07.28-ны өдөр хүртэл сунгах ажил хийгдэж байна. 60%-ийн /207.6 сая төгрөг/ санхүүжилт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>- Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, тайланг хүлээн авсан /ажлын санхүүжилт 148.8 сая төгрөг/.</p> <p>- Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг төлөвлөсөн боловч фосфорын ордыг ашиглалтын лиценз хувийн компанийн эзэмшилд байдаг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй болсон.</p> <p>- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Хатан далай" ХХК гүйцэтгэсэн. БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2023.08.30-ны хуралдаанаар тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн /ажлын санхүүжилт 118.8 сая төгрөг/. Ажлын явц 100%.</p>	
--	--	--	--	--	--	--	--

							- ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулан, тендерийг 6 удаа зарлаж, хүчингүй болсон. 2024.04.11 зарласан тендерийн ялагчаар "Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв" шалгарч, 2024.06.20-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2024.12.01-нд дуусна.		
47		6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2020 - 2022	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ, Холбогдох яамд	-	-	"ЭҮ" ТӨҮГ нь "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-тай "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээг 2021.09.17-ны өдөр байгуулан ажиллаж байна. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2022 оны 6-р сарын 24-нд хэлэлцүүлж СТР/22-03-01 дугаар дүгнэлт гаргуулсан. "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөл 2022.10.13-нд хуралдаж "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа ЭБМЗ-еер хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэгч ТЭЗҮ-ийг засварлан ЭҮ ТӨҮГ-ийн Техникийн зөвлөлийн 2023.02.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн тул УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023 оны 4-р сарын 04-ны өдөр хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2023.04.04-ны өдрийн СТР/23-01-04 дугаар дүгнэлтээр дэмжигдэж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ны өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн аваад байна. "ЭҮ"ТӨҮГ-ын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2023.04.24-ний өдрийн хурлаас 1 болон 2-р шатны ажлыг нийт ажлын 63.8%	0	ХҮБГ

						<p>гэж үнэлж санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны хуралдааны шийдвэрийн дагуу ТЭЗҮ-ийн дараагийн шатны ажил болох "Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил"-ыг "Майнинг шорт лонг терм" ХХК-иар хийлгэх шаардлагатай эсэхийг техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, "ЭҮ" ТӨҮГ-ын 2023.06.02-ны өдрийн А/353 тоот тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн 2023 оны Х/05; Х/30; ХII/22-ны өдрийн хурлаас нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэл хангалтгүй гэж дүгнэсэн. "ЭҮ" ТӨҮГ-ын дээд шатны удирдлагууд гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй уулзаж гэрээний үүргээ биелүүлээгүйг анхааруулсан ба гүйцэтгэгч компанийн захирал хүлээн зөвшөөрч, тайлбарыг албан бичгээр ирүүлэхээ илэрхийлсэн.</p> <p>- "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-аас "ЭҮ" ТӨҮГ-т ирүүлсэн 2024.03.06-ны өдрийн 06/24 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичигт "2023.08.29-ний өдөр "ЭҮ" ТӨҮГ-ын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байдлаар боловсруулсан зураг төслийг дүгнүүлэн гэрээг дуусгавар болгох саналтай байгаа"-гаа илэрхийлсэн. Иймд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хуулийн хэлтэс, ХОХААБГ тус ажлыг хянаж "Гэрээг дуусгавар болгох саналыг хүлээж авсан" тухай хариу албан бичгийг 2024.04.29-ний өдөр "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-д хүргүүлсэн. "Майнинг шорт лонг терм" ХХК-аас ирүүлсэн 2023.06.13-ны өдрийн 06/25 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичигт "3-р шатны ажил болох SX/EW үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын 60%-ийг гүйцэтгэсэн тул 503,752,401 төгрөгийн санхүүжилт хүссэн". "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас томилогдсон ажлын хэсгийн 2024.04.08-ны</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>өдрийн хурлаар "Иж бүрдэл дутуу, төрийн захиргааны холбогдох байгууллагуудаар хянуулан баталгаажуулаагүй зураг төслийг цаашид "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т ашиглах боломжгүй" гэж шийдвэрлэсэн тул Хуулийн хэлтэс, ХОХААГ цаашид авах арга хэмжээний талаар судалж байна.</p> <p>- Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдсэн.</p> <p>- Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын гэрээг ШУТИС-ийн МТС-тай 2024.02.14-ний өдөр байгуулсан. УУХҮЯ-ны шинжээч томилогдсон. Гэрээний хугацаа 2024.06.14-нд дууссан. Ажлын явц 80%.</p>		
48	7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК, Монгол банк	-	Улсын комисст хүлээлгэн өгнө.	<p>Төсөл хэрэгжүүлэгч "Эрдэнэс алт ресурс" ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба "түлхүүр гардуулах" нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, "Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. "Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий" ажлын хэсгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Дүгнэлтээр:</p> <p>1. ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх;</p>	0	ХҮБГ

						<p>2. “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын “Шинхай групп”-ийн саналтай дүйцэх саналыг хэрэгжүүлэх;</p> <p>3. Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг Монголбанкинд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх;</p> <p>4. Эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар “Түлхүүр гардуулах” төсөл хэрэгжүүлэгчээр өөрөөр нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гаднын банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах гэсэн дүгнэлт гарсан.</p> <p>Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яаманд 2023.02.17-ны өдрийн 02/475 албан бичгээр БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” ХХК -тай цаашид баримтлах байр сууриа яамны зүгээс илэрхийлсэн. Төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй байна.</p>			
49		9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	2021 - 2028	УУХҮЯ, Холбогдох яамд	1,195,017.6	Тоног төхөөрөмжийн захиалга, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. 20%	“Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалын хамт УУХҮСайдын 2023.01.03-ны өдрийн 01/04 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.01.11-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгах, төслийн нэгжийн чиг үүрэг, холбогдох баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхийг УУХҮСайдад даалгасан. Уг	0	ХҮБГ

							тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” төслийн нэгжийг татан буулгасантай холбоотойгоор төслийн чиг үүрэг, баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх Ажлын хэсгийг ТНБД-ын 2023.02.01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулж, зохион байгуулсан. Төсөлтэй холбоотой бүх баримт, материалыг 2023.03.30-ны өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээлгэн өгсөн. Мөн төслийн хүрээнд Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтын болон Тендерийн баримт бичигт санал авахаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.12.21-ний өдрийн 01/3357 албан бичгээр хүргүүлсэн ба 2023.06.05-ны байдлаар хариу албан бичиг ирүүлээгүй тул УУХҮСайдын 2023.06.05-ны өдрийн 01/1366 албан бичгийг дахин хүргүүлсэн. УУХҮСайдын 2023.06.05-ны өдрийн 01/1366 албан бичгийн хариуг ЭЗХЯ, СЯ-аас 2024.02.29-ний өдрийн байдлаар ирүүлээгүй байна.		
50	3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, Орон нутаг	-	Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 816.2 мян.тн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/36 тушаалаар Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайд орших Цэн тогоруу ордын газрын тосны нөөцийг баталгаат (1Р) зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель), үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,932.0 тонн (1.04 сая баррель), баталгаат+магадлалтай (2Р) зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррел), баталгаат+ магадлалтай+боломжтой (3Р) зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррел)-оор тус тус хүлээн авсан бөгөөд Цэн тогоруу ордыг газрын тосны ашиглалтын талбайд шилжүүлсэн. Зон Хэн Юу Тиан ХХК-ийн газрын тосны хайгуулын Галба XI талбайн Өлгий ордын нөөцийн тооцоо, баялгийн үнэлгээний тайланд дүгнэлт гаргуулахаар ЭБМЗ-өөс шинжээч томилон ажиллуулсан. БХГ-т Галба XI	70	ГТБГ

						<p>талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, Магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, Боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн болно.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/247, А/248, А/249 дүгээр тушаалуудаар газрын тосны хайгуулын 15 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 4 талбайд захиалгын материал ирүүлсэн. 3 талбайд ялагчийг тодруулан бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийн талаар хэлэлцээр хийн, эцэслэн тохиролцож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.</p>		
51		1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, Гэрээлэгч ААНБ	Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх 9 (газрын тос-2, нүүрсний давхаргын метан хий-6, шатдаг занар-1) гэрээ хэрэгжиж байна. Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний үр дүнгээр 2020 оноос хойш 5 бүтээгдэхүүн хуваах гэрээ	90	ГТБГ

		оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно.					байгуулсан. 2 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах шатанд байна. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын ажил: 2020 онд Төхөм Х (урд) талбайд 625.9 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн. Номгон IX талбайд 105 тууш км 2 хэмжээст микросейсмийн судалгаа хийж, метан хийн хайгуулын 7 цооног өрөмдсөн. 2021 онд Номгон IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 17 цооног 11,360.0 тууш.метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. 2022 онд Газрын тосны хайгуулын 2 талбайд 1050,9 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, Нүүрсий давхаргын метан хийн хайгуулын 6 талбайд нийт 527 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа, 37 цооног нийт 22,151.3 тууш.м өрөмдлөгийн ажил тус тус хийгдсэн. 2023 онд Газрын тосны хайгуулын 3 талбайд 3 цооног нийт 4,991 тууш.м өрөмдлөг, 547,5 км2 талбайд нийт 2,436 км 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, 1 талбайд нөөц бодох ажил хийгдэж байна. Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 5 талбайд 28 цооног нийт 10,784.73 тууш.м өрөмдлөг, 260 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 3 талбайд туршилтын олборлолтын ажил хийгдэж байна. 2024 оны эхний улиралд хайгуулын 13 гэрээлэгчийн 15 талбайд жилийн ажлын уулзалт хийж, 10 талбайд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан. Тус 10 талбайд нийт 3,000 тууш.км соронзон судалгаа, 610 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 50 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, нүүрсний давхаргын метан хийн 10 цооногт 4,310 тууш.м хайгуулын өрөмдлөг, 4 туршилтын хэвтээ цооног, газрын тосны хайгуулын 7 цооногт 15,480 тууш.м өрөмдөхөөр төлөвлөж нийт хөрөнгө	
--	--	--	--	--	--	--	---	--

							оруулалтын хэмжээ 46,3 сая ам.доллар байна.		
52		1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, Гэрээлэгч ААНБ	БХГ-ний дагуу тухай жилд оруулах ХО-р тодорхойлогдоно.	Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна.	Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн 57 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд IV, Онги V, Т1 талбайд Петровис ресурс ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус 3 талбайд 10 жилийн хугацаанд 30 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2019.12.11-ний өдрийн 435 дугаар тогтоолын дагуу 2020.10.01-ний өдөр газрын тосны хайгуулын Тариач XV талбайд Чайна голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 3 жилийн хугацаанд 12,4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2020.04.22-ны өдрийн 143 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Тавантолгой ХХХIII талбайд Эрдэнэс метан ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 10 жилийн хугацаанд 25 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Гурвантэс ХХХV талбайд Тэлмэн ресурс ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 10 жилийн хугацаанд 8,9 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. 2020 оноос хойш Газрын тосны хайгуулын 1, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 5 талбайд нийт 6 бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайнуудад нийт 76,3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн ажиллаж байна. 2024 оны эхний улиралд хайгуулын 13 гэрээлэгчийн 15 талбайд жилийн ажлын уулзалт хийж, 10 талбайд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан. Тус 10	90	ГТБГ

						талбайд нийт 3,000 тууш.км соронзон судалгаа, 610 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 50 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, нүүрсний давхаргын метан хийн 10 цооногт 4,310 тууш.м хайгуулын өрөмдлөг, 4 туршилтын хэвтээ цооног, газрын тосны хайгуулын 7 цооногт 15,480 тууш.м өрөмдөхөөр төлөвлөж нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 46,3 сая ам.доллар байна.		
53		1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, Гэрээлэгч ААНБ	Гэрээлэгчдийн хайгуул, судалгааны ажлын үр дүнтэй уялдуулан нөөц тогтоох ажлыг зохион байгуулсан байна.	Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн "Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1Р)" зэрэглэлээр 1 151 194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137 931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай (2Р)" зэрэглэлээр 3 051 724.0 тонн (23.01 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай+боломжтой (3Р)" зэрэглэлээр 5 385 942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Матад ХХ талбайн газрын тосны нөөцийг бүртгэж авснаар газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн. Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших "Петро Матад" ХХК-ийн газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Матад-ХХ талбайн 213.93 км2 газрыг газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг 2023.07.05-ны өдрийн Засгийн газрын	100	ГТБГ

							<p>хуралдаанаар хэлэлцүүлэн 265 дугаар тогтоолыг гаргуулаад байна. Уг тогтоолын 2 дэх заалтыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд АМГТГ-ын даргын тушаалаар Улсын тусгай хэрэгцээний талбайтай давхцал бүхий иргэдийн газрыг чөлөөлөх, газрын нөхөх олговрыг тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан газар дээр 2 удаа очиж айл өрхтэй уулзалт зохион байгуулж газар чөлөөлөх гэрээ байгуулж, нөхөх олговрын хэмжээг тохиролцоод байна. Газрын тосны хайгуулын Галба XI талбайн Өлгий ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд дүгнэлт гарган ЭБМЗ-р хэлэлцүүлэн зохиогчийн ирүүлснээр нөөцийн хүлээн авсан.</p> <p>Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, Магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, Боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн болно.</p>		
54		1.5. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ	Шаардлагатай ХО	ГТ-ны олборлолт 816.2 мян.тн	Газрын тосны экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээлгэх талаар Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт 2022.04.08-ны өдөр	50	ГТБГ

		хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.				<p>1/935 тоот албан бичгийг хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 тоот тогтоол гаргуулсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар 2022.05.19-ний өдрийн 78 дугаар Ерөнхий сайдын захирамж гарч Ажлын хэсгийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулан ажиллаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК болон "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2023.05.17-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж 21 дүгээр тэмдэглэл гаргуулсан.</p> <p>Монгол Улсын хэмжээнд 43.40 сая тонн ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд 11.1 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 32.0 сая тонн байна. 2024 онд 4,850,000 баррель буюу 659,202 тонн газрын тос олборлож экспортлохоос 2024 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн байдлаар нийт 2,078,005 баррель буюу 281,984 тонн газрын тос олборлож, 2,048,265 баррель буюу 178,509 тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Олборлолтын гүйцэтгэл 42.85 хувь, экспортын гүйцэтгэл 42.23 хувьтай байна.</p>	
--	--	---	--	--	--	---	--

55	2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.	2020 - 2024	СЯ, УУХҮЯ, "МГТБҮ" ТӨХХК		Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90%	Тос дамжуулах хоолойн трассын дагуу байр зүйн зураглал, инженер геодези, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж нарийвчилсан солбицлын цэгүүдийг тодорхойлон хоолойн трассын тэнхлэгээс 2 тал руу тус бүр 100 метр (нийт 200 м) зурвас газарт аливаа газрын давхцлыг арилгасан. Хоолой дайран гарах Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймагт дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан улсын тусгай хэрэгцээнд авахыг эдгээр аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр тус тус гарсан. Хоолойн трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай БХБЯ-аас ирүүлсэн 3Г-ын "Нууц" тогтоолын төсөлд 2024.03.20-ны өдөр албан бичгээр хариуг хүргүүлсэн. Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудал 3Г-ын 2024.05.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж шийдвэрлэгдсэн. Төслийн гүйцэтгэл 2024.05.29-ний өдрийн байдлаар хоолой цувих ажил нийт 256.7 км, хоолойн гагнуурын ажил нийт 232.1 км хийгдээд байна. гүйцэтгэл 2024.5.01-ний байдлаар 52.0-тай.	50	ГТБГ
56	2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, "МГТБҮ" ТӨХХК, АМГТГ	-	Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90%	Бүтээн байгуулалтын ажилд тулгамдаад байсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 3Г-ын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч Норинко компанид барилгын ажмл эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулсан. Төслийн гүйцэтгэл 2024.05.29-ний өдрийн байдлаар хоолой цувих ажил нийт 256.7 км, хоолойн гагнуурын ажил нийт 232.1 км хийгдээд байна. гүйцэтгэл 2024.06.01-ний байдлаар 52.0-тай.	50	ГТБГ
57	3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дотоодын түүхий эдэд	2020 - 2024	УУХҮЯ, ХЗДХЯ, СЯ, "МГТБҮ" ТӨХХК		2020-2022 онд хийж гүйцэтгэж эхэлсэн барилга-угсралтын ажлуудыг	ЕРС01-99,8%, ЕРС02-1,07%, ЕРС03-2,23%, ЕРС04-11,58%-ийн тус тус гүйцэтгэлтэй, ерөнхий дүнгээр 12.49%-ийн гүйцэтгэлтэй байна.	30	ГТБГ

		тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.				дуусгаж, лицензит байгууламжийн барилга-угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 90%			
58		3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, ХЗДХЯ, СЯ, "МГТБҮ" ТӨХХК	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулсан.	100	ГТБГ
59		3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	УУХҮЯ, ХЗДХЯ, СЯ, "МГТБҮ" ТӨХХК	-	2020-2022 онд хийж гүйцэтгэж эхэлсэн барилга-угсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилга-угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 90%	Төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, багц ажлын ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын төлбөрийг шилжүүлэх тухай 35 хүсэлтийг СЯ-нд хүргүүлж ажиллав. Төслийн бүтээн байгуулалтын ажилд тулгамдаад байсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч Мега Инженеринг компанид барилгын ажмл эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулсан. Мөн өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр ААНОАТТХуульд	30	ГТБГ

							нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэж хуулийнт төсөл УИХ-ын чуулганы 2024.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж батлагдсан.		
60		3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, ААНБ		Шатахууны хангамж тогтвортой байна. 2.3 сая тонн	2024 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 1.1 сая гаруй тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд: 90-ээс доош октантай автобензин 2557 тонн, 90-ээс дээш октантай автобензин 357,6 мян.тонн, дизель түлш 674,8 мян.тонн, шатдаг хий 18,5 мян.тонн, ТС-1 агаарын хөлгийн түлш 31,9 мян.тонн, бусад газрын тосны бүтээгдэхүүн 62.0 мян.тонн байна. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тогтвортой үргэлжилж байна.	90	ГТБГ
					2,834,500.0				
61		3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, ААНБ		Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 35 хувьд хүрсэн байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,159,387 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,078,849 тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 164,198 тонн буюу нийт шатахууны 16 хувийг эзэлж байна.	50	ГТБГ
62		3.6. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр	2020 - 2024	УУХҮЯ, ААНБ, АМГТГ	-	Төслийн барилга, угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 50%	Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0 га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна. Уг төслийн санхүүжилт	30	ГТБГ

		байгуулахад дэмжлэг үзүүлнэ.					тодорхойгүй шалтгаанаар саатсан талаар төсөл хэрэгжүүлэгч компани мэдээ ирүүлээд байна.		
63		3.7. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ, ХЗДХЯ, СЯ	-	Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон байна. 50%	ЗГХЭГ-ын дарга болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2021.02.26-ны өдрийн 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит "Эрчис Ойл" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ, "Эрдэнэс метан" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2021.03-р сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн.	30	ГТБГ
64	3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах	1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ.	2021 - 2024	Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ, ЭХЯ	-	Судалгааны ажил үргэлжлэн хийгдэнэ	ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. Байгалийн хий дамжуулах хоолойн	100	ГТБГ

	<p>Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.</p>						<p>шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХУСайдын 2022.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулсан. Мөн Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох яамдаас санал авч ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулах тухай хүсэлтийг УУХУСайдын 2022.04.28-ны өдрийн 01/1231 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд шугамын чигийн дагуу дахин шалгаж талбайн давхцалыг гаргаж байна. Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих төслийн дэд бүтэц түүний бүтээн байгуулалт, ТЭЗҮ зураг төсөлтэй холбоотой байгууллагын нууцад хамаарах мэдээллийг солилцох талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон "Газопровод Союз Восток" ХХК-ийн хооронд Нууцлалын гэрээг 2022.10.06-ны өдөр байгуулж, гэрээний биелэлтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар болон "Газпром" НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу байгалийн хий дамжуулах хоолой барих төслийн нарийвчилсан зураг төслийн баримт бичиг боловсруулах ажлыг дуусгаж, одоогийн байдлаар зураг төслийн баримт бичигт магадлал хийлгэж, байгалийн хий дамжуулах хоолой болон түүний дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг төслийн хэрэгцээнд авахаар эрчимтэй ажиллаж байна. Эдгээр ажлуудыг</p>		
--	---	--	--	--	--	--	---	--	--

65			2. ОХУ, БНХАУ-ыг холбосон хийн хоолой Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулж, төслийн нэгжийг мэдээллээр хангана.	2020 - 2021	Шадар сайд, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ, БХБЯ	-	Төслийн нэгж байгуулагдсан, трассын судалгаа хийгдэж байна.	Монгол Улсын Шадар сайдаас 2020.01.28-ны өдрийн ЗГ-2/58 дугаар албан бичгээр ирүүлсэн ОХУ, БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн холбогдох материалын хамт 2020.03.05-ны өдрийн 03/646, 2020.10.27-ны өдрийн 01/2497 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан. ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. Тухайн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн хэмжээнд байрших ашигт малтмалын болон газрын тосны талбайн мэдээллийг гаргаж төслийн нэгжид хүргүүлсэн.	100	ГТБГ
66	3.6.3. Зорилт	2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.	2021 - 2024	ЗТХЯ, УУХҮЯ, ТХААГ, ХХ	108,000.0	Цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц	Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч Юу Би Метан ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэх үйл ажиллагаа явуулсан. Тус компани 2021 онд Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг УОК-т хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна.	50	ГТБГ	

							Зам тээвэр, хөгжлийн яам үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.		
67	3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ	-	-	Бэрэн групп ХХК-ны 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй байгаа ба Хөгжлийн банкны зээл, өрийн асуудлаар "Бэрэн групп" ХХК-ийг хууль хяналтын байгууллагаас шалгаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон ба 2023 оныг дуустал хугацаанд (2024.02.29 буюу одоог хүртэл) төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх талаар аливаа үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.	70	ХҮБГ
68		2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ	-	Шилний үйлдвэрийн зүгшрүүлэлт тохируулгын ажил хийгдэнэ.	"Эрдэс плазм" ХХК нь шилний үйлдвэрээ Багахангай дүүрэгт байгуулахаар төлөвлөж байгаа ба үйлдвэрийн үндсэн түүхий эдийн судалгааг хийж гүйцэтгэн Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт байрлах Баян-Уул судлын цахиурын ордын нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн 2023.04.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. БХБЯ үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.	30	ХҮБГ

69		3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн ЗДТГ	-	Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсэн байна.	“Вестерн холд” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа жилд 300 мян.тн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах хүчин чадалтай “Ховд эко цемент”-ийн үйлдвэр 2022.10.28-ны өдөр ашиглалтад орсон ба үйлдвэрийн Чулуунцар бутлах хэсгийг 2023.04.21-ний өдөр ашиглалтад оруулан ажиллаж байна.	100	ХҮБГ																																		
70		4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ БХБЯ, Хувийн хэвшил	-	Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалын ашиглалтыг сайжруулна.	ЭБМЗ-ийн хуралдаанаар 2024 оны 5 дугаар сарын байдлаар хувийн хөрөнгөөр хийгдсэн барилгын материалын түүхий эдийн 13 ордын үр дүнгийн тайланг хэлэлцэн, нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Үүнд:	70	ГБГ, УУБГ, ХҮБГ																																		
								<table border="1"> <thead> <tr> <th>Орд</th> <th>Тоо</th> <th>Хэмжих нэгж</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шохойн чулуу: 2</td> <td>27,924.99</td> <td>мян.тн/тн</td> </tr> <tr> <td>Барилгын чулуу /дайрга/: 3</td> <td>7,208.00</td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Боржин</td> <td></td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Өнгөлгөөний чулуу: 1</td> <td>15,471.79</td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Гөлтгөнө</td> <td></td> <td>мян.тн</td> </tr> <tr> <td>Шавар</td> <td></td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Элс хайрга: 1</td> <td>1,129.76</td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Элс: 1</td> <td>376.75</td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Элсэн чулуу</td> <td></td> <td>мян.м3</td> </tr> <tr> <td>Базальт: 1</td> <td>12,251.49</td> <td>мян.тн</td> </tr> </tbody> </table>	Орд	Тоо	Хэмжих нэгж	Шохойн чулуу: 2	27,924.99	мян.тн/тн	Барилгын чулуу /дайрга/: 3	7,208.00	мян.м3	Боржин		мян.м3	Өнгөлгөөний чулуу: 1	15,471.79	мян.м3	Гөлтгөнө		мян.тн	Шавар		мян.м3	Элс хайрга: 1	1,129.76	мян.м3	Элс: 1	376.75	мян.м3	Элсэн чулуу		мян.м3	Базальт: 1	12,251.49	мян.тн		
Орд	Тоо	Хэмжих нэгж																																									
Шохойн чулуу: 2	27,924.99	мян.тн/тн																																									
Барилгын чулуу /дайрга/: 3	7,208.00	мян.м3																																									
Боржин		мян.м3																																									
Өнгөлгөөний чулуу: 1	15,471.79	мян.м3																																									
Гөлтгөнө		мян.тн																																									
Шавар		мян.м3																																									
Элс хайрга: 1	1,129.76	мян.м3																																									
Элс: 1	376.75	мян.м3																																									
Элсэн чулуу		мян.м3																																									
Базальт: 1	12,251.49	мян.тн																																									
								Эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой																																			

						харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэдэгт тогтоогдсон байна.			
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
71	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаныг үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024	Яамд, ТАЗ, УАкадеми		Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	1. Уул уурхайн сайдын эрхлэх асудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичиг, хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон тайлагналд хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. 2. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах зорилтын хүрээнд байгууллагын албан хаагчдыг мэрэгшүүлэх, ур чадварыг сайжруулах зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/128 дугаар Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “УУХҮЯ-ны төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх” хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гаргах бөгөөд 2024 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар сургалт, семинар, зөвлөгөөнд давхардсан тоогоор 87 албан хаагчийг, мэрэгшүүлэх сурагалтад 12 албан хаагчийг хамруулсан бөгөөд 2024 он гарсаар сургалт, семинар, зөвлөгөөнд 38 албан хаагчийг, мэргэшүүлэх сурагалтад 6 албан хаагчийг хамруулсан байна.	100	ТЗУГ
72	4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн	1. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй	2020 - 2022		-	Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Тооллого явуулах тухай” А/319 дугаар тушаалаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тэсрэх материалын үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчинд	100	УУБГ, ГТБГ

	үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.	байдал, хяналтыг сайжруулна.				хяналтыг сайжруулна.	тооллого явуулж, шинэчилсэн бүртгэл хийх Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах нийт 107 тусгай зөвшөөрөлтэй 94 аж ахуйн нэгжийн үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинд тооллого явуулж, хяналт тавьж ажилласан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна.		
73	4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх	4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ, СЯ, ГХЯ	-	Үйлдвэр ашиглалтад орох боломжтой.	ЕРС01-99.8%, ЕРС02-1.07%, ЕРС03-2.23%, ЕРС04-11.58%-ийн тус тус гүйцэтгэлтэй, ерөнхий дүнгээр 12.49%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, багц ажлын ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын төлбөрийг шилжүүлэх тухай 35 хүсэлтийг СЯ-нд хүргүүлж ажиллав. Төслийн бүтээн байгуулалтын ажилд тулгамдаад байсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч Mega Инженеринг компанид барилгын ажмл эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулсан. Мөн өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр ААНОАТТХуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэж хуулийнт төсөл УИХ-ын чуулганы 2024.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж батлагдсан.	100	ГТБГ

	чиглэлээр идэвхтэй ажиллана.								
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
74	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024	УУХҮЯ, АНЗДТГ, БОАЖЯ МХЕГ	40,000	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан тайлангаар: -техникийн нөхөн сэргээлтийг 836.2 га талбайд, -биологийн нөхөн сэргээлтийг 473.5 га талбайд, -дүйцүүлэх хамгаалах ажлыг 18,896.7 га талбайд хийсэн байна. -"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1575.74 га талбайд 2,753,478 ширхэг мод тарьсан байна.	100	УУБГ
75	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024	БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ ОБЕГ, НЗДТГ, ҮХГ	-	Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.	2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 905 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолноос бүх төрлийн шатахуун 844 мянган тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 146 мянган тонныг импортлоод байна. Евро-5 стандартын шатахууны гадаад хил үнэ 2024 оны 05 дугаар сард өмнөх сараас тонн тутамд 47 ам.доллараар буурч ирсэн байна. Нүүрсний уурхайн метан хийг ашиглах: Ашигт малмал, газрын тосны газар Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2018-2021 онд 6 талбайд 4 гэрээлэгчтэй Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан. Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 6 талбайд 2024 оны батлагдсан төлөвлөгөөгөөгөөр нийт 77 орчим сая ам.долларын төсөвт өртөг бүхий геологи, хайгуулын ажил хийхээр байна.	90	ГТБГ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН								60.41	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР